



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/НЗ

Улаанбаатар хот

┌ Зочид буудал, дэн буудал, амралтын ┐
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Бодь монгол ХХК-ны "Бест центр" зочид буудлын 14/31, Кондитер Улаанбаатар ХХК-ны "Шинэ-Алтай" зочид буудлын 16/020, Грийт Монголиа винд экспедишн ХХК-ны "Вондер монголиа" дэн буудлын 15/051, Батхаан групп ХХК-ны "Батхаан" амралтын газрын 15/056, Гоо билгүүд ХХК-ны "Гоо билгүүд" дэн буудлын 16/001, Наранбулаг трейд ХХК "Наранбулаг" зочид буудлын 13/94, Аргалжирэм ХХК-ны "Футура" зочид буудлын 13/201, Сэрх-Уул ХХК-ны "Алтан цайз-2" зочид буудлын 15/061 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт,


1150500176

олголтод хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

6. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Отгонсүвд/-д үүрэг болгосугай.

ДАРГА *D. Batm* Д БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 05 сарын 19 өдрийн № дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Бодь монгол ХХК	2679639	Бест центр	ЧД-ийн 5-р хороо Их тойруу-15
2	Кондитер Улаанбаатар ХХК	2626942	Шинэ-Алтай	СХД-ийн 18-р хороо ЭТӨЧ-Толгойт-28
3	Наранбулаг трейд ХХК	2745852	Наранбулаг	БГД-ийн 4-р хороо П.Жасрайн гудамж-27а
4	Сэрх-Уул ХХК	2657112	Алтан цайз-2	БГД-ийн 4-р хороолол 12-р хороо 10-р байр
5	Аргал жирэм ХХК	2043602	Футура	БГД-ийн 20-р хороо Дундгол өөрийн байр

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2017 оны 05 сарын 18
өдрийн А/43 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Шанд аттракшн ХХК	5884896	Говь аттракшн	СБД-ийн 5-р хороо Их өргөө 20-11
2	Грийт Монголиа винд экспедишн ХХК	5912717	Вондер монголиа	СБД-ийн 4-р хороо Юб таун 38-85
3	Гоо билэгүүд ХХК	5436354	Гоо билэгүүд	БГД-ийн 22-р хороо Зүүн нарангийн 18-70
4	Иргэн Б.Саранхүү	Чи59052708	Мүүн	БЗД-ийн 10-р хороо АОС-1
5	Иргэн Н.Батжаргал		Энх төв	БЗД-ийн 5-р хороо ЭТӨЧ 64-1
6	Захгүй Мэнэн ХХК	5380073	Мичид	БЗД-ийн 16-р хороо 46-1
7	Захгүй Мэнэн ХХК	5380073	Марал	БЗД-ийн 16-р хороо 1320-13

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны 05 сарын 18 өдрийн А.13 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

1117139265
УОА0453 5284325

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2017.05.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Батхаан групп ХХК	2027968	Батхаан	СХД-ийн 24-р хороо Бумбатын ам
2	Дүнхэн уулын буурал улиастай ХХК	5884276	Ресорт ворлд тэрэлж	НД-ийн 6-р хороо Мэлхий хадны сав газар

--ooOoo--